

Аудитын сэдэв:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**“МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ, СУМЫН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу нийцлийн аудитыг хийлээ.

**АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН
2021-2022 ОНД ХАМААРАХ 973.8 СЯА ТӨГРӨГИЙН АВЛАГЫН
ҮЛДЭГДЭЛТЭЙ БАЙНА.**

Тайланг хүргүүлсэн этгээд: Дорнод аймгийн татварын хэлтэс, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
мэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: Ouyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

**Чойбалсан хот
2023 он**

Аудитын харилцан хамаарал:

Малын тоо толгойн албан татварын хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж, төсвийн орлого бүрдүүлэх, уг орлогоор малчдын ахуй амьдралд ач холбогдолтой үйлчилгээг үзүүлэх, тогтвортой хөдөө аж ахуй, урт хугацааны хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт зарцуулалт нь Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Төсвийн тухай хууль, "Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх тайлагнах журам", Орон нутгийн хөгжлийн сангийн журмаар зохицуулагдаж байна.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

“Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, сумын татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль бусад холбогдох хууль журам, тогтоол шийдвэрүүдтэй нийцэж байгаа эсэх*
- *Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх*
- *Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт үр нөлөөтэй эсэх.*

Аудитад 14 сумын ИТХ, ЗДТГ, Татварын хэлтсийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын гол үр дүн:

БҮЛЭГ А. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН БАЙНА.

А.1.1 Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасан татвар төлөх хугацаа нь Төсвийн тухай хуультай уялдахгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт зарцуулалт нь Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Төсвийн тухай хууль, "Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх тайлагнах журам", Орон нутгийн хөгжлийн сангийн журмаар зохицуулагдаж байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1-д "Албан татвар төлөгч нь энэ хуулийн ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7-р сарын 15, 12-р сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн жилд багтаан төлөвлөсөн арга хэмжээг санхүүжүүлэхэд хүндрэл учруулж байна. Татварын орлого төсвийн жилийн сүүлээр төвлөрснөөс үүдэн нийт төлөвлөсөн арга хэмжээний 26.4 хувь нь цаг хугацаандаа хэрэгжээгүй зөрчил илэрсэн.

А.1.2 Малын тоо толгойн албан татвар нь Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болж байна.

А.2.1 Малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг Баяндун Чойбалсан сумд малын төрөл харгалзахгүй тогтоосон байна.

Чойбалсан сум нэг толгойд ногдох албан татварын хэмжээг малын төрөл харгалзахгүй 500

төгрөг, Баяндун сум нэг толгойд ногдох албан татварын хэмжээг малын төрөл харгалзахгүй 240 төгрөгөөр тогтоосон нь малын бэлчээрт учруулах хор хөнөөлийг тооцоогүй мөн энэ талаар хууль журамд нарийвчлан зааж өгөөгүйтэй холбоотой байна. Үүнээс үүдэн журамд заасан, зайлшгүй шаардлагатай хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдахад хүрч байна.

БҮЛЭГ Б. Малын тоо толгойн албан татварын 2021-2022 оны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн 775.3 сая төгрөгийн 32 ажил хийгдээгүй байна.

Б.1. Малчин, мал бүхий этгээдийн 2021, 2022 оны малын тоо толгойн албан татвар 2023 оны 5 дугаар сарын 24-ний байдлаар 973.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Б.2. Малын тоо толгойн албан татварын орлогоор 2021-2022 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 26.4 хувь нь хэрэгжээгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогоор 2021-2022 онд 2,500.4 сая төгрөгийн 121 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 775.3 сая төгрөгийн 32 ажил хийгдээгүй байна. Энэ нь татварын орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүйгээс шалтгаалсан байна.

БҮЛЭГ В. МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

В.1. Малчин, мал бүхий этгээдийн 2023 оны татварын ногдлыг үүсгээгүй байна.

Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журмын 2.2-т *Татварын алба нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан өмнөх жилийн мал тооллогын дүн, нэгдсэн мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан тайлант жилийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээн авч, “Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д холбогдох мэдээллийн санг үүсгэнэ* гэж заасан байна. Малчин, мал бүхий иргэний 2023 оны татварын ногдлыг цахим санд оруулаагүй байна.

В.2. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Малын тоо толгойн албан татварын орлогоор хийхээр төлөвлөсөн ажлын 26.4 хувь хэрэгжээгүй байна. Санхүү төрийн сангийн хэлтсээс сумдын санхүүгийн албаны 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ч сумын ИТХ болон Засаг дарга ОНХС-гийн журмын 3.2.2-д “Тухайн шатны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих”, 3.4.3-т “сум дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 32.1 хувиар тасарсан нь Дорнод аймгийн Татварын хэлтэс нь Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлийн 75.1.2-д “татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих”, 75.1.3-д “төсвийн орлогыг бүрдүүлэх” гэсэн үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Аудитын дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасан татвар төлөх хугацаа нь Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх талаарх заалтуудтай уялдахгүй байна.

2. Малын тоо толгойн албан татвар нь Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хангахад зориулагдсан байна.
3. Малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг Баяндун, Чойбалсан сумд малын төрөл харгалзахгүй тогтоосон байна.
4. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг 2021 онд 9 сум, 2022 онд 2 сум батлаагүй байна.
5. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг мал тооллогын дүнд үндэслэн төлөвлөөгүй байна.
6. Малын тоо толгойн албан татвар ногдуулалтад журмын дагуу малчин, мал бүхий этгээдийг бүрэн хамруулсан байна.
7. Малын тоо толгойн албан татварын орлогоор 2021-2022 онд хэрэгжүүлсэн 89 төсөл, арга хэмжээ нь ОНХС-гийн журамд тусгайлан заасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээтэй нийцэж байна.
8. Малын тоо толгойн албан татварын орлогоор 2021-2022 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 26.4 хувь нь хэрэгжээгүй байна.
9. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-д малчин, мал бүхий иргэний 2023 оны татварын ногдуулалтыг 2023 оны 06 дугаар сарын 09-ний байдлаар үүсгээгүй байна.
10. Сумын татварын улсын байцаагч малын тоо толгойн албан татварын төрлийн албан татвар төлөгчөөр бүртгэсэн тухай татвар төлөгчдөд бүрэн мэдэгдээгүй байна.
11. Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
12. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын зөвлөмж:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар зөвлөмжийг өгч байна.

Сумдын ИТХ-ын дарга нарт

1. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Сумдын Засаг дарга нарт

1. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Аймгийн Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаад

1. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Хавсралт:

Аудитаар нийт 2,379.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 2,337.3 сая төгрөгийн зөрчилд 15 /14 сум, Татварын хэлтэс/ албан шаардлага, 42.0 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 29 /сумдын ИТХ-14, Засаг дарга-14, Татварын хэлтэст/ зөвлөмж өгч, холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлэх 4 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах.
Үүнд:

1. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг Төсвийн тухай хуультай нийцүүлэх талаар Засгийн газарт уламжлах.
2. "Отор нүүдлийн зорилгоор аймаг дамжин мал туух, мал амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журам"-ыг "Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх тайлагнах журам"-тай нийцүүлэх талаар Засгийн газарт уламжлах
3. "Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-гийн хөгжүүлэлтийг сайжруулах талаар ТЕГ-т уламжлах.

Малчин, мал бүхий иргэний 2023 оны татварын тайлангийн ногдлыг "Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-нд үүсгэх талаар ТЕГ-т уламжлах.

АЛБАН ШААРДЛАГА:

Сумдын Засаг дарга нарт

1. Малын албан татварын орлогын төлөвлөгөөг боловсруулан батлуулах, орлогын нэр төрлөөр ханган ажиллах.
2. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг мал тооллогын дүнд үндэслэн төлөвлөх.
3. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг хангаж ажиллах.
4. Малын тоо толгойн албан татварын хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Аймгийн Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаад

1. Малын тоо толгойн албан татварын өмнөх оны 973.8 сая төгрөгийн дутуу төлөлтийг барагдуулах.

ТӨЛБӨРИЙН АКТ:

Матад сумын Засаг дарга Д.Баттүлгэ-д

1. Матад сум нь нэг бүр нь 20.0 сая төгрөгийн 3 мал угааврын ванн хийлгэх ажлын гэрээг "Нарангийн рашаан өндөр" ХХК-тай 2022.07.27-ны өдөр байгуулсан байна. Уг ажлын гүйцэтгэл гэрээний дагуу хийгдээгүй байхад 42.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна.

Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

